



100
БАЯНГОЛ

ШИЙДЛЭЭ..
СОНГОЕ!
ШИНЭЧЛЭЛЭЭ ҮРГЭЛЖЛҮҮЛБЭ

СОДНОМЗУНДУЙН ЭРДЭНЭ

2024 ОНЫ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН
9-Р ТОЙРОГ БАЯНГОЛ ДҮҮРЭГТ
АРДЧИЛСАН НАМААС НЭР ДЭВШИГЧ



ЭРХЭМ ХҮНДЭТ БАЯНГОЛЧУУД АА!

Бүрэн эрхт Ардчилсан Монгол Улсын иргэн бүр Үндсэн хуулиар олгогдсон сонгох, сонгогдох эрхээ эдэлж хэрэгжүүлэх чухал мөч Та бидний өмнө ирээд байна. Энэ бол иргэн Таны болохгүйг халах, бурууг шүүх, зөвийг дэмжих эрх юм. Та бүхэн Ардчилсан намыг дэмжиж Монгол Улс, нийслэл, дүүргийнхээ, хөгжлийг хамтдаа бүтээнэ гэдэгт итгэж байна.

Баянгол дүүргийн иргэд Ардчиллыг дэмжиж, эрх чөлөөт нийгмийг бүтээн босгох үйлсэд ямагт тэргүүн эгнээнд байж, 2008-2012 онд Ардчилсан намыг багаар нь дэмжиж, хамтдаа улс, орныхоо хөгжлийг тодотгох шинэчлэлийн суурийг тавьж чадсан.

Баянголчууд 2012-2016 онд том, жижиг нийлсэн 14 эмнэлгийг шинээр байгуулж, иргэдийнхээ эрүүл мэндийн чанар хүртээмжийг хоёр дахин нэмэгдүүлж, улсдаа ганц Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх хөгжлийн ордонг дүүрэгтээ байгуулж байлаа.

Ахмадын эмнэлэг, хуримын ордон, хүүхэд хөгжлийн ордонтой анхны дүүрэг болж, Баянгол усан спорт сургалтын төв, Баянгол спортын ордон, Баянгол хүүхдийн зуслан гээд хүүхэд залуучууд, хүндээ чиглэсэн олон ажлыг богино хугацаанд сэтгэл, зүтгэл байвал хэрхэн хийж болдгийг харуулсан он жилүүдийг бид хамт бүтээсэн билээ. 2012-2016 онд Ардчилсан намын бүтээн байгуулалтын он жилүүд байлаа. Тэр дундаа Баянгол дүүргийн Ардчилсан намын Шинэчлэлийн баг дүүрэгтээ хөгжлийг авчирч чадсан юм.

Гэтэл өнөөдөр төр нь иргэдийнхээ аз жаргалтай байдлын төлөө ажиллах ёстой атал иргэд нь төрийн томчуудынхаа эрх мэдлийн төлөө үйлчилдэг нийгэм бий болов. Ардчилал, шударга ёсны үнэт зүйлсээс бид буцаж хэдэн шат ухрав. Иргэдийн түрүүвч нимгэрч, эрх мэдэлтнүүдийн тансаглал хэрээс хэтрэв. Эдийн засаг томорсон гэх ч иргэдийн орлого, худалдан авах чадвар нэмэгдсэнгүй харин ч буурлаа.

Монгол улс хөгжлөөс ухарч, монгол иргэн бүр боломжоо хулгайлуулсан алдагдсан найман жил байлаа.

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчилалаа хамгаалан бэхжүүлж, шударга ёс, хувь хүний эрх, эрх чөлөө, хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн үзэл баримтлалтай намын хувьд Ардчилсан нам алдагдсан найман жилийн алдааг засах "БҮТЭН МОНГОЛ БҮРЭН АРДЧИЛАЛ" мөрийн хөтөлбөрөөс Баянгол дүүрэгт хэрэгжүүлэх "БАЯНГОЛ ТЭРГҮҮЛЭХ 100" ажлаас та бүхэнд танилцуулж байна.

Та бүхэн бидэнд итгэл хүлээлгэн Ардчилсан намаас нэр дэвшигчдийг багаар нь дэмжиж Монгол Улс, нийслэл, дүүргийнхээ, хөгжлийг хамтдаа бүтээнэ гэдэгт итгэж байна.

Содномзундуйн ЭРДЭНЭ



СОДНОМЗУНДУЙН ЭРДЭНЭ

ТӨГССӨН СУРГУУЛЬ МЭРГЭЖИЛ

- 1981 НИЙСЛЭЛИЙН 75-Р ДУНД СУРГУУЛЬ
- 1981 - 1984 ЦЭРГИЙН НЭГДСЭН ДЭЭД СУРГУУЛЬ, ЦЭРГИЙН КОМАНД, ВМП АШИГЛАЛТЫН ИНЖЕНЕР
- 1995 - 1998 ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛЬ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙЧ БАКАЛАВР
- 1999 - 2000 УДИРДЛАГЫН АКАДЕМИ, ТӨРИЙН УДИРДЛАГЫН АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖЕР
- 2000 - 2002 ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛЬ, ХУУЛЬ ЗҮЙН УХААНЫ МАГИСТР
- 2005 GERMAN УЛС, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ДЭЭД КУРС
- 2006 АНУ-Д НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ДЭЭД КУРС
- 2013 УДИРДЛАГЫН АКАДЕМИ, УДИРДАХУЙН УХААНЫ ДОКТОР

АЖЛЫН ТУРШЛАГА

- 1990 БАГАНУУР ДҮҮРГИЙН МОНГОЛ АЖИЛЧДЫН ЗӨВЛӨЛИЙН МХЗЭ-ИЙН ХОРООНЫ ДАРГА
- 1992 - 1996 "МОЛОР-ЭРДЭНЭ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ
- 1996 - 2000 БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА
- 2004 - 2008 УНДЕГ-ЫН ДАРГА, НДҮЗ-ИЙН ГИШҮҮН, НДЕГ-ЫН УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ
- 2007 - 2008 НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ
- 2008 - 2012 УИХ-ЫН ГИШҮҮН
- 2012 - 2016 УИХ-ЫН ГИШҮҮН, ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
- 2016 - 2020 УИХ-ЫН ГИШҮҮН
- 2016 - 2017 УИХ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛГИЙН ДАРГА



СОНГУУЛЬТ АЖИЛ

- 1990 БАГАНУУР ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНЫ ДАРГА
- 1990 - 1991 МОНГОЛЫН АРДЧИЛСАН НАМЫН НИЙСЛЭЛИЙН ЗӨВЛӨЛД УЛС ТӨРИЙН АЖИЛТАН
- 1992 УИХ-ЫН СОНГУУЛЬД ЭВСЭЖ ОРСОН МОАН, ҮДН-ЫН ТӨВ ШТАБЫН ДАРГА
- 1996 - 2000 БГД-ИЙН ИТХТӨЛӨӨЛӨГЧ
- 1997 - 2000 ОНД МҮАН-ЫН НИЙСЛЭЛИЙН НАМЫН ДАРГА, ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН
- 2000 МОАН-ЫН ДАРГА
- 1995 - 2017 БАЯНГОЛ ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМЫН ДАРГА
- 2000 - 2007 АН-ЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛДӨХ ХОРОО, ГҮЙЦЭТГЭХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН
- 2002 - 2006 МОНГОЛ АРДЧИЛСАН ХОЛБООНЫ ДАРГА
- 2004 - 2008 ТӨГС ЭРДЭМ САНГИЙН ТЭРГҮҮН
- 2009 АРДЧИЛСАН ХҮЧНИЙ ХОЛБООНЫ ТЭРГҮҮН
- 2005 - 2011 НИЙСЛЭЛИЙН АРДЧИЛСАН НАМЫН ДАРГА
- 2017 - 2021 АРДЧИЛСАН НАМЫН ДАРГА
- 2021 МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ САГСАН БӨМБӨГИЙН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ
- 2012 - 2022 АН-ЫН УЛС ТӨРИЙН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН АРДЧИЛСАН НАМЫН ДАРГЫН ЗӨВЛӨХ


ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

- АЛТАН ГАДАС ОДОН
- ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН
- АРДЧИЛЛЫН ДЭЭД ШАГНАЛ "ЧИНГИС ХААНЫ ОДОН"



МОНГОЛД АРДЧИЛЛЫН ГАЛ ХЭЗЭЭ Ч БӨХӨХ
ЁСГҮЙ. ТҮҮНИЙГ САХИН ХАМГААЛЖ,
ТЭМЦЭХЭЭС ӨӨР СОНГОЛТ НАДАД ҮГҮЙ.

Содномзундуйн ЭРДЭНЭ





НАДАД БАЙГАА ХАМГИЙН ТОМ ХӨРӨНГӨ БОЛ МИНИЙ ГЭР БҮЛ

Би долоон хүүхэд, 11 ач зээтэй, өнөр гэр бүлийн өрхийн тэргүүн, жирийн л нэг аав, өвөө.

Гэр бүл, үр хүүхэд маань надад байгаа хамгийн үнэт хөрөнгө. Аавыг минь Содномзундуй гэдэг Монголын сагсан бөмбөгийн нэрт зүтгэлтэн, Монголын анхны мастеруудын нэг, бүх насаа л энэ салбартаа зориулсан хүн.

Аавынхаа сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэх хүсэл мөрөөдлийг биелүүлж, үйл хэргийг үргэлжлүүлэн Монголын сагсан бөмбөгийн спортыг дэлхийн тавцанд амжилттай гаргаж чадсандаа баяртай байдаг.

Ээж минь биеэ маш сайхан авч явдаг, арьс ширний нэгдэлд оёдолчноос цехийн мастер болтлоо ажиллаж, цехийнхээ савхин хувцасыг өмсөж бүтээгдэхүүнээ сурталчилдаг байсан одоогийнхоор бол загвар өмсөгч гэсэн үг юм даа.

Үлгэр жишээ ийм л сайхан хоёр хүний хүү болж, бага нас минь тухайн үеийн хүүхдүүдийн л адил өнгөрсөн. Аав ээжийнхээ үргэлжлэл болж өвлүүлсэн нэрийг нь бүтэн авч явахыг хичээж явдаг. Үр хүүхдүүддээ ч үнэнч шударга, зөв явахыг захиж сургадаг. Хүүхдүүд минь эхнээсээ өрх тусгаарлаад өөр өөрсдийн амьдралаа бүтээж явна. Том хүү өөрийн жижиг барилгын компанитай, том охин Э.Содгэрэл "Гурван тамир" сургуулийн захирлаар ажилладаг.

Бүгд л бусдын адил сурсан мэргэжлийнхээ дагуу өөр өөрсдийн ажил амьдралаа авч яваа.

Төрд ажилладаг хүн байхгүй.

Бага охин Э.Содханд одоо есөн настай.

Эхнэр Н.Нинжбадгар маань

"МОЛОР ТРЕЙД" ХХК-иа удирдаж авч явдаг.



Хэлэх дуртай үг?

Юм нэгээр дуусдаггүй.

Таны амьдралдаа баримталдаг гол зарчим?

Хүн чанартай, ноён нуруутай нэр бүтэн явах юмсан гэж боддог.

Танд байгаа хамгийн үнэтэй зүйл юу вэ?

Үр хүүхэд.

Хүүхдэдээ хэлж захидаг хүмүүжлийн гол сургаал?

Хэзээ ч, хаана ч явсан хүнд тустай, зөв байж, үнэн яв гэж захидаг.

Зөв хүн байх хамгийн гол дүрэм?

Хэлсэн, зорьсондоо байх.

Амьдралаас сурсан хамгийн том сургамж?

Аливаа бэрхшээл, саад хэцүүг давах сэтгэлийн тэнхээ, хат суусандаа л маш олон зүйлийг давж туулсан.

Та юуг хамгийн сайн хийж чаддаг вэ?

Аливаа юмыг төгс зохион байгуулах, ямар нэг ажлыг төгс төгөлдөр хийхийг эрмэлздэг. Нэг л юм дутуу хийчихвэл сэтгэл их зовнидог.

Таны зорилгыг нэг уулын оргил гэж үзвэл таны амжилт хэдэн хувьд нь яваа вэ?

Өөрийн ажил амжилтандаа сэтгэл дүүрэн явдаг. Хэрвээ би жижиг зүйл дээр ч сэтгэл дундуур явбал намайг дэмждэг, хажууд үргэлж хамт байдаг гэр бүл, найз нөхөд, үзэл бодол нэгт олон мянган хүмүүсээ үгүйсгэсэн хэрэг болно шүү дээ.

Таныг илэрхийлэх 3 үг, 3 зүйл?

Зөрүүд, шартай, аливаа юмыг хийхдээ бүрэн төгс хийж дуусгахыг хичээдэг.

Ардчилал таны үгээр?

Ардчилал бол хуулийг хэрэгжүүлдэг, нэг хүний эрхээр, нөгөө хүний эрх хязгаарлагддаг ЭРХ ЧӨЛӨӨ юм.

Монгол орны хамгийн үнэт баялаг юу вэ?

Монгол ХҮН.

Улсынхаа хөгжлийг ирээдүйн 30 жилээр төсөөлбөл?

Улс орныг удирдаж яваа хүмүүсийн бодлого, үйл ажиллагаанаас ихээхэн шалтгаална. Гэхдээ би эх орноо хөгжлийн зөв чигээ олсон Ардчилсан Монгол Улс байна гэдэгт итгэдэг.



ТӨР ТҮМНИЙХЭЭ ТӨЛӨӨ ЗҮТГЭСЭН 30 жил...

34 Ардчилсан хувьсгал эхлэхэд тэргүүн эгнээнд зогсож явсан цагаас эхлээд **34** жилийн хугацаанд Ардчиллын үнэт зүйлсийг хамгаалахын төлөө зүтгэсээр ирсэн.

1 Үзэл баримтлал, үнэт зүйлээ хамгийн анх дээд шүүхэд бүртгүүлсэн анхны улс төрийн намын дарга.

260 УИХ засгын газрын **260** гаруй тогтоол шийдвэрийн төслийг боловсруулалцан гаргаж хэрэгжилтийг хангах ажлын хэсгийн дагра болон гишүүнээр ажилласан.

71 Хуулийн төслийг санаачлан **41** хуулийг батлуулж хэрэгжүүлж чадсан.

10 Ажилласан жил нөхөн тооцох тухай хуулийг санаачлан батлуулж хэрэгжүүлсэн. Энэ хуулийн хүрээнд одоогын байдлаар сая орчим хүн хамрагдан тэтгэвэртээ гарсан байна.

14 Баянгол дүүрэгт шинэчлэлийн багаараа том жижиг **14** эмнэлэг барьж, эрүүл мэндийн салбарт томоохон өөрчлөлт, шинэчлэл, хөрөнгө оруулалт хийж чадсан.

25 Эрүүл мэндийн салбарын түүхэнд **25** жилийн хугацаанд нэг ч эмнэлэг барьж ашиглалтад оруулаагүй байсан. Харин 2014 онд Баянгол дүүрэгт 2-р шатлалын эрүүл мэндийн төв эмнэлэг барьж ашиглалтад оруулсан.

19K Канад, финланд технологиор сургуулиудийг давхарлаж хүүхдийн суудлын тоог **19,000** нэмэгдүүлснээр 3 ээлжээр хичээллэж байсныг 2 ээлжээр хичээллэдэг болгосон.

15 Ардчилал эрх чөлөөг хамгаалахын тулд Ардчилсан хүчний холбоог байгуулан **15** жил удирдан ажиллав. "Хонхны дуу"-г цуурайтуулсан Ардчиллын дууч, алтан хараацай С.Цогтсайханы хөшөөг Баянгол дүүрэгтээ босгов.

ЭХЗ Монголын үндэсний сагсан бөмбөгийн холбоог үүсгэн байгуулж, удирдан ерөнхийлөгчөөр ажиллаж байх хугацаандаа Монголын сагсан бөмбөгийг тэр дундаа багийн спортыг олимпод оролцох эрхийг анх удаа авч тив дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс алт, мөнгө, хүрэл медалийг авч аавынхаа мөрөөдлийг биелүүлэв.

50 Баянгол дүүргийн **50** жилийн ойд зориулж, олон олон бүтээн байгуулалтыг хийж хөгжил шинэчлэлтийн түүхийг бүтээв.



АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ ТУСГАСАН БАЯНГОЛ ДҮҮРЭГТ ХЭРЭГЖИХ 100 АЖЛУУДААС

Өрийн дарамтгүй, төрийн дарамтгүй монголыг бий болгоно.

Хууль ёсыг дээдэлсэн, шударга ёсны итгэл үнэмшлийг бий болгож, хувь хүний эрх, эрх чөлөө, эдийн засгийн баталгааг хангах бодлого баримтална.

Иргэндээ ээлтэй төрийн бодлогыг хэрэгжүүлж, төрийг иргэдэд үйлчилдэг болгох бүх нөхцлийг бүрдүүлнэ.

Залуучуудын хөгжлийн "Community center" байгуулж, чөлөөт цагаа өнгөрөөх, хамтдаа хөгжих, суралцах орчныг бүрдүүлнэ.

Угсармал орон сууцны дулаан алдагдлыг бууруулах, гадна пасад дээврийн дулаалгын ажлыг үргэлжлүүлнэ.

Гэр хорооллыг инженерийн дэд бүтцэд холбож амины орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, амьдран суух байшингаа барихад урт хугацаатай, хүү багатай, орон сууцны ипотекийн зээлээр санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллана.

Гэр хорооллын дундах гудамж, хайс, хашааг сэргээж нэгдсэн байдлаар тохижуулж, өнгө төрхийг сайжруулан аюулгүй байдлыг ханган, камержуулалтыг бүрэн шийднэ.

Хувийн өмчийн халдашгүй байдлыг баталгаажуулж хамгаалсан хууль эрх зүйн орчинг бий болгоно.

Төрийн албыг чадварлаг, цомхон болгож, цааснаас татгалзсан цахим технологи нэвтрүүлнэ.

Иргэний үндсэн эрхийн баталгааг хангаж, парламентын засаглалыг бэхжүүлэхийн зэрэгцээ шүүх, прокурорын байгууллагын үйл ажиллагааг ил тод, шударга шуурхай байлгана.

Хамтын тэтгэврийн тухай хуулийг сэргээж мөрдүүлнэ.

Оюутны сургалтын зээлийн тогтолцоог сайжруулна.

Яаралтай, тургэн тусламжийн үйлчилгээг тэлж, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шилжүүлэх замаар иргэдэд ойр болгоно.

Хиймэл оюун ухаан технологийн давуу талыг ашигласан хөгжлийн бодлогыг боловруулж хэрэгжүүлнэ.

Цэцэрлэг, сургуулийн нэг ангийн хүүхдийн тоог 30-аас хэтрүүлэхгүй байх стандарт хэрэгжүүлнэ.

Тэтгэврийг цалингийн өсөлт, инфляцийн түвшинтэй уялдуулах бодлого баримтална.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан олон талт мэргэжлийн үйлчилгээг нэмэгдүүлнэ.

Баялаг бүтээгчдээ дэмжиж, монгол хүний орлогыг нэмэгдүүлнэ.

Ус, агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.



АЛДАГДСАН 8 ЖИЛИЙГ ДҮГНЭСНИЙ ҮР ДҮНД АЛДААГ ЗАСЧ, МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ ЭРЧИМТЭЙ ХӨГЖСӨН, ХУУЛИЙН ЗАСАГЛАЛ, ШУДАРГА ЁС ТОГТСОН, ХҮН БҮР АЖИЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭН, ОРЛОГО НЬ АМЬДРАЛ АХУЙД ХҮРЭЛЦСЭН, ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АЖИЛЛАЖ, АМЬДАРСАН ХҮНЛЭГ, АРДЧИЛСАН НИЙГМИЙГ ЦОГЦЛООХЫН ТӨЛӨӨ ӨНӨӨДРӨӨС ӨӨРЧЛӨӨ.

УИХ-ын Сонгуулийн 9-р тойрог Баянгол дүүрэгт Ардчилсан намаас нэр дэвшигч

Содномзундуйн **ЭРДЭНЭ** Цэрэндуламын **АЛТАНЦЭЦЭГ** Цэдэвийн **ТАВАНЧУЛУУ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ

САНАЛЫН ХУУДАС

(НАМ, ЭВСЭЛД ӨГСӨН САНАЛЫГ ТЭМДЭГЛЭХ ХЭСЭГ)

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн ___ тойргийн ___ аймаг/дүүргийн ___ дугаар хэсэг

Та өөрийн сонгохыг хүссэн 1 нам, эвслийн нэрийн өмнөх зууван улаан дугуйг дүүргэн будаж саналаа тэмдэглэнэ үү. 1-ээс илүү нам, эвсэл санал тэмдэглэсэн бол саналын хуудсыг хүчингүйд тооцохыг анхаарна уу.

- Нам, эвслийн нэр
 Ардчилсан нам
 Нам, эвслийн нэр

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ

САНАЛЫН ХУУДАС

(СОНГУУЛИЙН ТОЙРОГТ НЭР ДЭВШИГЧИД ӨГСӨН САНАЛЫГ ТЭМДЭГЛЭХ ХЭСЭГ)

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн ___ тойргийн ___ аймаг/дүүргийн ___ дугаар хэсэг

Та өөрийн сонгохыг хүссэн ___ нэр дэвшигчийн өмнөх зууван улаан дугуйг дүүргэн будаж саналаа тэмдэглэнэ үү. ___-ээс илүү, эсхүл дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн бол саналын хуудсыг хүчингүйд тооцохыг анхаарна уу.

Нам	Ардчилсан нам	Нам
<input type="radio"/> Нэр дэвшигч	<input checked="" type="radio"/> Содномзундуйн Эрдэнэ	<input type="radio"/> Нэр дэвшигч
<input type="radio"/> Нэр дэвшигч	<input checked="" type="radio"/> Цэрэндуламын Алтанцэцэг	<input type="radio"/> Нэр дэвшигч
<input type="radio"/> Нэр дэвшигч	<input checked="" type="radio"/> Цэдэвийн Таванчулуу	<input type="radio"/> Нэр дэвшигч
Нам	Нам	Нам
<input type="radio"/> Нэр дэвшигч	<input type="radio"/> Нэр дэвшигч	<input type="radio"/> Нэр дэвшигч
<input type="radio"/> Нэр дэвшигч	<input type="radio"/> Нэр дэвшигч	<input type="radio"/> Нэр дэвшигч
<input type="radio"/> Нэр дэвшигч	<input type="radio"/> Нэр дэвшигч	<input type="radio"/> Нэр дэвшигч
Нам	Нам	Бие даан нэр дэвшигч
<input type="radio"/> Нэр дэвшигч	<input type="radio"/> Нэр дэвшигч	<input type="radio"/> Нэр дэвшигч
<input type="radio"/> Нэр дэвшигч	<input type="radio"/> Нэр дэвшигч	<input type="radio"/> Нэр дэвшигч
<input type="radio"/> Нэр дэвшигч	<input type="radio"/> Нэр дэвшигч	<input type="radio"/> Нэр дэвшигч



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
АРДЧИЛСАН НАМ

ТЭРГҮҮЛЭХ **100** ХӨТӨЛБӨР
БАЯНГОЛ

АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН
БАЯНГОЛ ДҮҮРЭГТ ХЭРЭГЖИХ 100 АЖИЛ

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМЫН СОНГУУЛЬ ЭРХЭЛСЭН БАЙГУУЛЛАГА

ЦАХИМ ХУВИЛБАР



НАМАЙГ УНШУУЛ